Ил тод байдал

Олон нийтийн оролцоо

Хяналт

# МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Нээлттэй нийгэм форум ТББ-ын
Хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам

2022 оны 9-р сар

International Budget Partnership

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

## “Төсвийн нээлттэй байдлын судалгаа 2021”

- Зохион байгуулагч: Олон улсын төсвийн түншлэл байгууллага (www.internationalbudget.org)
- Хамрагдсан орны тоо: 120

## Монгол Улсын дүн

| | | |
|---|---|---|
| Ил тод байдал<br>**60** /100<br>(Төсвийн нээлттэй байдлын индексийн оноо) | Олон нийтийн оролцоо<br>**13** /100 | Төсвийн хяналт<br>**76** /100 |

**Монгол Улсын төсвийн нээлттэй байдал, 2006-2021 он**




**Төсвийн нээлттэй байдалд орсон гол өөрчлөлт**

- Иргэдийн төсвийг цахим хэлбэрээр цаг тухайд нь нийтэлсэн.
- Жилийн эцсийн тайлангийн иж бүрэн байдлыг сайжруулсан.

Нээлттэй нийгэм форум ТББ-ын Хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам

# Монгол Улсын төсвийн баримт бичгийн агуулгын иж бүрэн байдал

| Төсвийн баримт бичиг (Үнэлгээнд хамрагдсан төсвийн жил) | Баримт бичгийн агуулгын оноо |
|---|---|
| Төсвийн хүрээний мэдэгдэл (2021) | 95 |
| Нэгдсэн төсвийн төсөл (2021) | 61 |
| **Батлагдсан төсөв (2021)** | **39** |
| Иргэдийн төсөв (2021) | 58 |
| Нэгдсэн төсвийн явцын тайлан (2020) | 89 |
| **Нэгдсэн төсвийн Хагас жилийн тайлан (2020)** | **Боловсруулаагүй** |
| Нэгдсэн төсвийн жилийн эцсийн тайлан (2019) | 67 |
| Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан (2019) | 67 |



# Монгол Улс төсвийн ил тод байдлаа хэрхэн дээшлүүлэх вэ?


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ

ТӨСВИЙН БАРИМТ БИЧИГ

Улаанбаатар хот
2021 он

**Төсвийн төслийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлыг сайжруулахын тулд тусгах мэдээлэл**



## ТӨСВИЙН ТООЦООЛОЛ

- Төсвийн жилээс цааш хамгийн багадаа хоёр жилээр хийсэн төсвийн ангиллаарх орлогын тооцоолол (татварын болон татварын бус гэх зэрэг)



- Төсвийн тооцооллыг хийхдээ суурилсан хүүгийн түвшин
- Макро эдийн засгийн янз бүрийн төсөөлөл нь төсөвт үзүүлэх нөлөөлөл(өөрөөр хэлбэл, мэдрэмжийн шинжилгээ)-ийн мэдээлэл



## ӨР

- Тухайн жилийн болон өмнөх жилүүдийн өрийн бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл
- Засгийн газрын цаашдын өр төлбөр болон түүний санхүүгийн тогтвортой байдлыг урт хугацаанд үнэлсэн тооцоолол.

## Монгол Улс төсвийн ил тод байдлаа хэрхэн дээшлүүлэх вэ?




- ЗГ-ын бодлогуудын санхүүгийн нөлөө хүн амын янз бүрийн бүлэгт ямар байхыг харуулсан зардлын хувилбарууд

### Төсвийн төслийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлыг сайжруулахын тулд тусгах мэдээлэл

### ТӨСВИЙН ЗАРЛАГА

- Төсвийн жилээс цааш хамгийн багадаа хоёр жилээр хийсэн төсвийн аль нэг ангиллаарх зарлагын тооцоолол
- Төсвийн жилийн өмнөх жилийн зарлагыг зориулалтаар ангилсан байдлаар

**Төсвийн ангилал**

| | |
|---|---|
| Эдийн засгийн | Төсвийн захирагчаар |
| Зориулалтаар | Хөтөлбөрөөр |

| Зардлын хувилбарууд | | | |
|---|---|---|---|
| Хүйсээр | Насаар | Орлогын түвшнээр | Бүс нутгаар |

# Монгол Улс төсвийн ил тод байдлаа хэрхэн дээшлүүлэх вэ?

**Монгол Улсын нэгдсэн төсвийн хагас жилийн тайлан**


МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Улаанбаатар хот




**Excel**

**CSV**

**Json**

- Хагас жилийн тайланг боловсруулж цахим хэлбэрээр цаг тухайд нь нийтлэх;
- Баталсан төсөвт тухайн жилийн орлого болон зарлагын мэдээллийг эдийн засгийн иж бүрэн ангилал болон чиг үүргийн ангиллаар тооцон оруулах;
- Өрийн дүнг жилийн эцсийн тайланд тусгах;
- Иргэдийн төсвийн иж бүрэн байдлыг сайжруулах;
- Төсвийн тоон мэдээллийг PDF, Word хэлбэрээр нийтэлж буй нь компьютероор боловсруулалт хийхэд хялбар бус тул .csv, .xls/.xlsx, .json гэх мэт форматаар нийтлэх.

# Төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоо

| 0 /100 | 11 /100 | 25 /100 | 33 /100 |
|---|---|---|---|
| Боловсруулах (Засгийн газар) | Батлах (хууль тогтоох байгууллага) | Хэрэгжүүлэх (Засгийн газар) | Аудит хийх (аудитын дээд байгууллага) |

## Төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоог хэрхэн дээшлүүлэх вэ?

**Улсын Их Хурлын зүгээс:**

- Олон нийтийн, эсвэл иргэний нийгмийн байгууллага(ИНБ)-ын төлөөлөгч төсөв батлагдахаас өмнөх болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн сонсголд оролцож мэдүүлэг өгөх боломж бүрдүүлэх;
- Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны төрөл бүрийн сувгаар дамжуулан Төсвийн төслийн талаар олон нийтийн зүгээс санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**Сангийн яамны зүгээс:**

- Төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах;
- Эмзэг болон төлөөлөл багатай бүлгийг шууд, эсвэл тэдгээрийг төлөөлдөг ИНБ-уудаар дамжуулан төсвийн хэлэлцүүлэгт оролцуулах.

**Үндэсний аудитын газрын зүгээс:**

- Аудитын шалгалт хийх үйл явцад олон нийт хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлсэн албан ёсны механизмыг бий болгох;
- Аудитын сэдвийн чиглэлээр иргэдээс өгсөн саналыг аудитын хөтөлбөр боловсруулахдаа хэрхэн ашигласан талаарх тайланг иргэдэд хүргэх.

# Төсвийн хяналтын тогтолцоо

**Хууль тогтоох байгууллагын хяналт**




**Аудитын хяналт**




## Төсвийн хяналтаа хэрхэн дээшлүүлэх вэ?

**Улсын Их Хурлын зүгээс:**

- УИХ-ын байнгын хорооноос нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн жилийн явцын тайланг хэлэлцэж, гарсан дүгнэлтийг цахимаар нийтэлж байх;
- Засгийн газар төсвийн жилийн дундуур төсвийн хөрөнгийн хуваарилалтыг захиргааны нэгжүүдийн хооронд шилжүүлэх тохиолдолд УИХ-тай зайлшгүй зөвшилцдөг байх.

**Үндэсний аудитын газрын зүгээс:**

- Аудит хийх үйл явцыг хөндлөнгийн байгууллагаар нягтлуулах;
- Нэгдсэн төсвийн жилийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд тайлангийн агуулгыг тоймлосон Хураангуй хэсэг оруулах.

# Монгол Улсын Нээлттэй засаглалын түншлэлийн 2022-2023 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд төсвийн чиглэлээр туссан амлалтууд

## Зорилт 6: Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх



Төсвийн үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтуудыг төсвийн хууль тогтоомжинд оруулах, үүний дотор Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн журамд зарим зохицуулалтыг нэмж тусгах

ШИЛЭН ДАНС

Шилэн дансны нэгдсэн системийг НЗТ-ийн 4-р төлөвлөгөө хэрэгжих хугацаанд нээлттэй өгөгдлийн зарчмаар иж бүрэн шинэчлэх



Улсын төсвийн үйл явц, хөрөнгө оруулалт, зарцуулалт тусгай сангууд, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын талаар иргэд, олон нийт, татвар төлөгчид жилийн турш саналаа өгч хэлэлцүүлэг өрнүүлж байх цахим талбарыг бий болгох

# Монгол Улсын Нээлттэй засаглалын түншлэлийн 2022-2023 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд төсвийн чиглэлээр туссан амлалтууд

**1. Төсвийн үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтуудыг төсвийн хууль тогтоомжид оруулах:**

- Өнөөгийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
- Тэдгээр зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах үүрэг бүхий зөвлөлдөх механизмыг талуудын оролцоотойгоор ажиллуулах
- Холбогдох зохицуулалтыг НЗТ-ийн Үндэсний 4-р төлөвлөгөөний хугацаанд төсвийн хууль тогтоомжид оруулах.



**Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн журамд дараах зохицуулалтуудыг нэмж тусгах:**

- Улсын төсвийн хөрөнгөөр ирэх онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний маягтад шинээр эхлэх төслүүдийн хувьд “тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг нийт төсөвт өртөгт эзлэх хувиар”, шилжих төслүүдийн хувьд “анх батлагдсан төсөвт өртөг” гэсэн мэдээллүүдийг нэмэх;
- Төсвийн тодотгол хийгдэх тохиолдолд УИХ-д өргөн баригдах хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтын тусгайлсан маягтуудыг боловсруулах.

***Анхаарал хандуулсанд баярлалаа.***